



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар A/104

Чингис хот

Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 20 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны A/58 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймаг нь Коронавируст халдварт /Ковид-19/ илрээгүй Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоолын дагуу “Ногоон түвшин”-д хамаарч байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлсүгэй.

2. 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 08:00 цагаас эхлэн архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэх аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг хэвийн цагийн хуваарыт шилжүүлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

3. Коронавируст халдварт /Ковид-19/-аас сэргийлэх чиглэлээр гаргасан Улсын Онцгой комиссын даргын “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаалыг сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг төрийн болон төрийн өмчит аж ахуй нэгж, байгууллага, иргэн хуулийн этгээд, бүх сумдын Засаг дарга наарт үүрэг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар /Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/ Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

4. 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаа эх тэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Түр журам батлах тухай” A/53 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эцэг, эхчүүд, Боловсрол, соёл урлагийн газар /Б.Мөнхцэцэг/-т, тушаалын

2.

хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус даалгасугай.

5. Аймаг хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөн нээсэнтэй холбогдуулан Улсын Онцгой комиссын 2021 оны 20 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт, Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Авто тээврийн төв /Б.Ганбат/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Онцгой байдлын газар /Ж.Эрдэнэбат/-т тус тус үүрэг болгосугай.

6. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор түргэвчилсэн оношлуур, халдварт хамгааллын хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд 21 000 000 /хорин нэгэн сая/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Гамшигийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ

